

Бичиг үсгийн баяр

Гурвансайхан суманд бүсчлэн зохион байгуулагдсан “бичиг үсгийн баяр”-т 6а ангийн 18 суралцагчийг монгол хэлний багш С.Түмэнбаатар бэлтгэж оролцуулав. Тэд аймгийн дунджаас Монгол бичгийн минутын уншлагт 46.5% үг уншсан амжилттай.



Үсэглэлийн баяр

Бдугаар сарын 29нд 1-р ангийн суралцагчдын цагаан толгойн 35 үсгээ үзэж дуусан уншиж бичиж бодож сурсны баяр “Эрдмийн баяр”-аа тэмдэглэлээ. Бяцхан суралцагчид сурч мэдсэн дуу, шүлэг, бүжгээ сургуулийн нийт багш суралцагч, эцэг эхдээ тайлагнаж. Өндөр үнэлгээ авсан Б.Бат-Өлзий багштай 1а ангийн суралцагчид 90%-ийн амжилттай тайлант уншлага өглөө.



Орон нутгийн тойрон аялал

Монгол улсын боловсролын тэргүүний ажилтан Н.Дэлгэрсайханы нэрэмжит Монгол хэлний олимпиадад Б.Бат-Өлзий багштай суралцагчид тэргүүн байр эзлэж байгалийн үзэсгэлэнт газраар аялах эрхийн бичгээр шагнагдсан билээ. 2019 оны 04 сарын 26 нд Б.Бат-Өлзий М.Оюунбаяр С.Түмэнбаатар багштай нэг өдрийн турш аялж Норовбанздад зориулсан хөшөө, задгай театр үзэж байгалийн сайхантай танилцан түр саатав. Төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулж нандин дурсамжтай ирцгээлээ.



Аялалын хүүхдүүдийн сэтгэгдэл: Шүлэг бичсэн ба ангийн суралцагч Н.Батжаргал

Их газрын минь домогт чулуу

Олон янзын сүрлэг хад

Онцгойлж хармаар задгай театр

Онгон байгалийн сүр жавхлан

Уудам талд дэлгээтэй

Ихэс дээдсийн минь бидэнд үлдээсэн

Их газрын минь домогт чулуу

Инээж суугаа охин шиг

ид шидийн зураг байна

ирсэн зочдод зориулсан
зелдэг тухтай зуслан байна
өвөг дээдсийн минь өвлүүлж үлдээсэн
өнө эртний их газрын домогт чулуу

Хэлбэр дүрс нь өөр өөр
Хачин янзын үзэсгэлэн байна
Хэзээ ч очсон уйдмааргүй
Хөгжилтэй сайхан байгаль байна

Тэнгэр газраас бидэнд хайрласан
Дээдсийн заяатай их газрын минь домогт чулуу
Энэ сайхан байгаль эхээ
Эрдэнийн зүйлээр битгий солиорой
Энгийн хэвээр үлдээе гэвэл
Элдэв хог битгий хаяарай

Шүлэг бичсэн: ба ангийн суралцагч Б.Цэрэнсодном

Их газрын чулуу

Их талын эзэн чулуу
Их монголоор цуутай чулуу
Олон түмний мэлмийг баясгасан
Их газрын чулуу
Ихэс дээдсээс улбаатай
Ирмүүн өргөн их газрын чулуу
Ийм болохоор би

Их газрын чулуугаараа бахархдаг.

Шүлэг бичсэн: 6а ангийн суралцагч Н.Эмүжин

Их газрын чулуу

Дайчин бээсийн хошууны

дархан цаазат газар

дэлхийд цуурайтсан дуучны

алдарыг мөнхөлсөн хад

алсын газраас сүндэрлэн харагдах

алтан говийн чимэг болсон

их газрын чулуу минь